



АШИГТ МАЛТМАЛ,  
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/СЧ.

Улаанбаатар хот

Жилийн ажлын уулзалт зохион байгуулах  
тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 болон 9.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх ажил, үүрэгтэй холбогдуулан газрын тосны эрэл, хайгуулын гэрээлэгч компаниудтай хийх жилийн ажлын уулзалтыг 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.


2. Жилийн ажлын уулзалт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар, уулзалтын хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Жилийн ажлын уулзалтын үр дүнг 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэг /Ц.Эрдэнэбаяр/-т даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН


Хөтлөх Ашигт малтмал, газрын тосны газрын даргын  
20-р зууны 01 дүгээр / дугаар сарын 10 -ний/ны өдрийн  
104 дугаар /дүгээр/ тушаалын нэгдүгээр хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Ц. Эрдэнэбаяр /Газрын тосны салбарын асуудал хариуцсан орлогч дарга/
Ажлын хэсгийн дэд ахлагч	Б. Сүнжидмаа /ГТХХ-ийн дарга/
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга	Т. Батхишиг /ГТХХ-ийн мэргэжилтэн/ Ч. Магнайбаяр /ГТХХ-ийн мэргэжилтэн/
Ажлын хэсгийн гишүүд:	Р. Энхтайван /ХЭЗХ-ийн дарга/ Б. Золбообаяр /ГТХХ-ийн ахлах мэргэжилтэн/ А. Түвшинжаргал /ГТХХ-ийн мэргэжилтэн/ З. Цогтбаяр /ГТХХ-ийн мэргэжилтэн/ Л. Мөнгөнтөгс /ГТХХ-ийн мэргэжилтэн/ С. Пүрэвсүрэн /ГТХХ-ийн мэргэжилтэн/ Д. Цэрэнханд /ГТХХ-ийн мэргэжилтэн/ С. Дэмбэрэл /ГТХХ-ийн мэргэжилтэн/ Д. Чинзориг /ГТХХ-ийн мэргэжилтэн/ Ч. Амгалан /ХЭЗХ-ийн мэргэжилтэн/ Б. Оюун /ТЗУХ-ийн мэргэжилтэн/ Ч. Наранцэцэг /ТЗУХ-ийн мэргэжилтэн/ Э. Дуламсүрэн /ТЗУХ-ийн мэргэжилтэн/


Ашигт малтмал, газрын тосны газрын даргын  
2020 оны 01 дүгээр /дугаар сарын 01/-ний /ны өдрийн  
А/с/ дугаар /дүгээр/ тушаалын хоёрдугаар хавсралт



## УДИРДАМЖ

1. Гэрээлэгч компаниудын 2020 онд хийсэн хайгуулын ажлын үр дүн, газрын тосны хэтийн төлөвийг хэлэлцэх;
2. Гэрээлэгч компаниудын газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-ний хэрэгжилт /Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилт, хайгуулын ажлын доод хэмжээний биелэлт, хайгуулын болон байгаль орчны төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл, үр дүн, тайлан, төлбөр, урамшууллын төлөлт, ажиллах хүч, орон нутаг, талбай буцаалт, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардал, бусад/ болон байгуулсан санамж бичиг, протоколыг дүгнэх;
3. 2021 онд хийх хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг хэлэлцэх, холбогдох мэргэжилтнүүдийн гаргасан санал, дүгнэлтийг тусгуулах, удирдлагад танилцуулах, төлөвлөгөө төсвийг батлуулах;
4. БХГ түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгамдсан асуудлыг хэлэлцэх, удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх, шаардлагатай тохиолдолд санамж бичиг, протокол байгуулах;
5. БХГ-т талбай тус бүрээр хариуцсан мэргэжилтэн уулзалт зохион байгуулах бэлтгэх хангах, уулзалтын тэмдэглэл хөтлөх, илтгэх хуудас бичих, удирдлагад танилцуулах;
6. Эрлийн гэрээт компаниудын гэрээний хэрэгжилтийг дүгнэх, гэрээний хэрэгжилттэй холбоотой тулгамдсан асуудлыг хэлэлцэх, удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх, шаардлагатай тохиолдолд санамж бичиг, протокол байгуулах.

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын  
2021 оны ~~дүгээр~~ дугаар сарын ~~18~~...-ний/ны өдрийн  
А/С/А дугаар /дүгээр/ тушаалын гуравдугаар хавсралт



### УУЛЗАЛТЫН ХУВААРЬ

№	Гэрээлэгч компаниуд	БХГ-т талбай	Хугацаа
1	Метан газ ресурс ХХК	Тавантолгой XXXIII	2021.01.19
2	Шунхлай энерги ХХК	Сулинхээр XXIII	2021.01.26
3	Смарт ойл Монголиа ХХК	Эргэл XII	2021.01.27
4	Петровис ресурс ХХК	Богд IV, Онги V, Т1	2021.01.28
5	Голден Хорд ХХК	Номгон IX	2021.02.01
6	Монголын алт (МАК) ХХК	Төхөм X урд	2021.02.03
7	Вульф петролеум ХХК	Сүхбаатар XXVII	2021.02.04
8	Чайна Голден Сий Петролиум Эксплорэйшн Корпорэйшн ХХК	Тариач XV	2021.02.05
9	Макс ойл ХХК	Арбулаг XXIX	2021.02.08
10	Капкорп Монголиа ХХК, Петроматад ХХК	Онги V, Матад XX	2021.02.09
11	Магнай трейд ХХК	Баянтүмэн XVII	2021.02.10
12	Зон хэн юу тиан ХХК	Галба XI	2021.02.19
13	Монголиа глэвилл Увс петролеум ХХК	Увс I	2021.02.25
14	Шэйман ХХК	Нялга XVI	2021.02.26
15	Эн пи ай ХХК	Хөхнуур XVIII	
16	Эрлийн гэрээт компаниуд		